



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ

ЭМГ-ын ЭТҮХ-ийн дарга Ж.Отгонбайгал

2022 оны 03 сарын 28 - ны өдөр



Агуулга:

1. Бодлогын баримт бичиг
2. Статистик үзүүлэлтүүд
3. Ололт амжилт
4. Анхаарах асуудал
5. Цаашид



Бодлогын баримт бичиг

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго 3: Эрүүл мэндийг дэмжих

✓ Хэнийг ч орхигдуулахгүй,

✓ Нийт хүн амыг эрүүл, сайн сайхан амьдрах нөхцлөөр хангах

3.1 Эхийн эндэгдлийг 100,000 амьд төрөлтөд < 70 (2030 он)

3.2 Нярай ба 5 хүртэлх насны хүүхдийн сэргийлэх боломжтой эндэгдлийг боломжит түвшинд хүртэл буулгах (2030 он)

НҮБ-ын Эмэгтэйчүүд, хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн дэлхийн стратеги, 2016-2030

✓ 2030 он гэхэд, эмэгтэйчүүд, хүүхэд, өсвөр үеийнхэн бүр хаана ч өөрсдийн биеийн болон сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхны төлөө амьдрах эрхээ сайтар ойлгодог, нийгэм эдийн засгийн боломжтой, хөгжиж дэвшсэн тогтвортой нийгмийг бүтээхэд бүрэн оролцох боломжтой болно.



Бодлогын баримт бичиг

ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2030

- Дэлхийн дундаж эхийн эндэгдлийн харьцааг 100,000 амьд төрөлтөд 70-аас бага болгох
- Орон бүр 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртлэх насны хүүхдийн эндэгдлийг хамгийн багадаа 25 ба түүнээс доош болгон бууруулах
- Улс бүр 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдлийг хамгийн багадаа 12 ба түүнээс доош болгон бууруулах;

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ 2030 онд:

- Эхийн эндэгдлийн түвшинг 100,000 амьд төрөлтөд 15
- Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 9
- Нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 8 болгож бууруулах
- Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.



Бодлогын баримт бичиг

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

- 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- 2.2.1. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдэл, хөгжлийн бэрхшээл үүсгэж байгаа шалтгааныг тодорхойлж, хувь хүний онцлогт тохируулан урьдчилан сэргийлэх, оношлох тогтолцоог санхүүжүүлтийн аргатай нь уялдуулан бүрдүүлж, үйл ажиллагааг хэвшүүлнэ.
- 2.2.14. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхитэй оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”

- 2.1.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.



Бодлогын баримт бичиг

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2021 оны 12 сарын 09-ний **A/760** ТООТ ТУШААЛ:
“ЭХ, ХҮҮХЭД НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД” арга хэмжээний төлөвлөгөө:

- **Хугацаа:** 2021-2024 он
- **Хөрөнгийн эх үүсвэр:** Улсын төсөв, гадаадын зээл тусламж
- **Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт:**
 - 2021 онд: Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулсан
 - 2022 онд: Арга хэмжээний хэрэгжилт 40%-д хүрнэ
 - 2023 онд: Арга хэмжээний хэрэгжилт 50%-д хүрнэ
 - 2024 онд: Арга хэмжээний хэрэгжилт 70%-д хүрнэ
- **Арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага:**
- Үндсэн хариуцагч: ЭМЯ
- Хамтрагч: Аймаг, Нийслэлийн Засаг даргын тамгын газар
- Оролцогч: Эрүүл мэндийн байгууллагууд, ТББ, ААН, хувийн хэвшил



Бодлогын баримт бичиг

АИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 06 сарын 17-ны өдрийн №88 тогтоол:

“ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД” хөтөлбөр батлах тухай

- **Хугацаа:** 2021-2024 он
- **Хөрөнгийн эх үүсвэр:** Орон нутгийн төсөв, улсын төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хандив тусламж
- **Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт:**
 - 2021 онд: Хөтөлбөрөө боловсруулж батлуулсан, хэрэгжилт 20%
 - 2022 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 40%-д хүрнэ
 - 2023 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 70%-д хүрнэ
 - 2024 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 90%-д хүрнэ
- **Арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага:**
- Үндсэн хариуцагч: ЭМГ
- Хамтрагч: Аймаг, сумын Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн байгууллагууд
- Оролцогч: Төрийн болон ТББ, ААН, хувийн хэвшил



Бодлогын баримт бичиг

Хэрэгжиж буй тушаал, шийдвэр:

- ЭМС-ын 2021 оны **A/760** “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай
- ЭМС-ын 2020 оны **A/318** “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам”
- ЭМС-ын 2021 оны **A/182** “Гамшгийн үед иргэдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах заавар батлах тухай”
- ЭМС-ын 2021 оны **A/133** “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үед жирэмснийг хянах цахим үзлэгийн түр журам”
- ЭМС-ын 2021 оны **A/337** “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг “Комирнэти” (BNT162b2) вакцинаар дархлаажуулах тухай
- ЭМС-ын 2022 оны **A/33** “Шинэ коронавируст халдвар /КОВИД-19/-ын оношилгоо, эмчилгээний түр зааврыг шинэчлэн батлах тухай”
- ЭМС-ын 2019 оны **A/614** “Эхээс хүүхдэд ХДХВ, гепатитийн В вирус болон тэмбүүгийн халдвар дамжихыг зогсоох журам батлах тухай”
- ЭМС-ын 2020 оны **A/222** “Коронавируст халдвар (Covid19)-ын үед жирэмсэн эмэгтэй, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ”-г зохицуулах түр журам



Бодлогын баримт бичиг

ЭМАШТУ-нд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт
(ЭМС-ын 2017 оны А/129, 2019 оны А/52 тоот тушаал)

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ:

1. Жирэмсэн эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ

- Жирэмсэн үеийн тусламж, үйлчилгээ Эрүүл жирэмсний хяналт, эрсдэлтэй жирэмсний хяналт, илүү тээлт, эрт ба хожуу цус алдалт, манас таталт, манас таталтын урьдал, жирэмсний үеийн эмгэгүүд
- Төрсний дараах тусламж, үйлчилгээ Эхийн хяналт, төрсний дараах хяналт, тусламж, төрсний дараах цус алдалтын тусламж, ихэс үлдэлтийн үеийн тусламж, гэр бүл төлөвлөлт

2. Эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ

- Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээ Урьдчилан сэргийлэх үзлэг, гэр бүл төлөвлөлтөд хамруулах, умайн хүзүүний өмөн, хөхний өмөнг эрт илрүүлэх, эмэгтэйчүүдийн бусад өвчин эмгэг



Бодлогын баримт бичиг

Тогтвортой хөгжлийн зорилт:

Эхийн эндэгдлийг бууруулахаар хэрэгжүүлж буй арга хэмжээ нь:

- **ГБТ-ийн тусламж, үйлчилгээ** – Хүсээгүй жирэмслэлт, охидын жирэмслэлт, үр хөндөлтийг бууруулах
- **Жирэмсний хяналт** – Чанарыг сайжруулах
- **Хавсарсан эмгэг эмчлэх** – Жирэмслэлтийн болон төрөлтийн хүндрэл, эхийн ноцтой хүндрэл, амьгүй төрөлтийг бууруулах





Статистик үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт		2017	2018	2019	2020	2021	Өөрчлөлт
1	Амаржсан эх	Улс	73884	77058	77601	75694	71166	4528 тохиолдлоор буурсан
		Өмнөговь	1297	1536	1638	1677	1633	44 тохиолдлоор буурсан
2	Амьд төрөлт	Улс	74328	77528	78223	76261	71659	4602 тохиолдлоор буурсан
		Өмнөговь	1301	1552	1646	1680	1639	41 тохиолдлоор буурсан
3	Амьгүй төрөлт	Улс	471	455	415	416	401	15 тохиолдлоор буурсан
		Өмнөговь	11	1	4	9	11	2 тохиолдлоор өссөн
4	Амьгүй төрөлтийн түвшин	Улс	6,3	5,8	5,3	5,4	5,6	0,2-р өссөн
		Өмнөговь	8,4	0,6	2,4	5,3	6,7	1,4-р өссөн
5	Эхийн эндэгдэл	Улс	20	21	18	23	68	45 тохиолдлоор өссөн
		Өмнөговь	1	0	0	0	0	0
6	Эхийн эндэгдлийн харьцаа /100000 амьд төрөлтөд/	Улс	26,9	27,1	23,0	30,2	94,9	64,7-р өссөн
		Өмнөговь	76.8	0	0	0	0	0
7	Эхийн ноцтой хүндрэл	Улс	296	239	224	208	161	47 тохиолдлоор буурсан
		Өмнөговь	4	5	2	2	5	3 тохиолдлоор өссөн
8	Эхийн ноцтой хүндрэлийн харьцаа	Улс	4,0	3,1	2,9	2,7	2,2	0,5-р буурсан
		Өмнөговь	3,1	3,2	1,2	1,2	3,0	1,8-р өссөн

Статистик үзүүлэлтүүд



АМЬГҮЙ ТӨРӨЛТ, МОНГОЛ УЛС, 2017-2021 ОН

Аймаг	Амьд төрөлт					Амьгүй төрөлтийн тоо					Амьгүй төрөлтийн түвшин				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
Увс	2036	1912	1910	2024	1859	14	7	7	18	17	6.8	3.6	3.7	8.8	9.1
Төв	1197	1147	1102	1074	1129	4	3	11	5	10	3.3	2.6	9.9	4.6	8.8
Дорнод	1934	1957	1927	2005	1790	14	10	9	7	15	7.2	5.1	4.6	3.5	8.3
Баян-Өлгий	2849	2919	2990	2864	2927	25	22	13	18	23	8.7	7.5	4.3	6.2	7.8
Өмнөговь	1301	1552	1646	1680	1639	11	1	4	9	11	8.4	0.6	2.4	5.3	6.7
Улаанбаатар	38404	40703	41206	39779	36416	274	281	253	223	220	7.1	6.9	6.1	5.6	6.0
Сүхбаатар	1275	1307	1291	1345	1376	7	6	8	8	8	5.5	4.6	6.2	5.9	5.8
Хөвсгөл	2775	2881	2834	2728	2656	15	15	12	17	15	5.4	5.2	4.2	6.2	5.6
Улсын дүн	74328	77528	78223	76261	71659	471	455	415	416	401	6.3	5.8	5.3	5.4	5.6



Статистик үзүүлэлтүүд

Коронавируст халдварын хүндрэлтэй ба хүндрэлгүй бүлгийн КОВИД-19 дархлаажуулалтад хамрагдсан байдал нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. /Эхийн эндэгдлийн судалгаа 2021/

	Хүндрэл						Р Утга
	Үгүй		Тийм		Нийт		
	тоо	хувь	тоо	Хувь	тоо	хувь	
КОВИД - 19 вакцин							0.0001
Хийлгээгүй	7852	48.4%	829	52.7%	8681	48.8%	
1-р тун	1440	8.9%	196	12.5%	1636	9.2%	
2-р тун	6542	40.3%	521	33.1%	7063	39.7%	
3-р тун	381	2.3%	28	1.8%	409	2.3%	
Эмнэлэгт хэвтсэн эсэх							0.0001
Үгүй	1259	7.8%	10	0.6%	1269	7.1%	
Тийм	14955	92.2%	1564	99.4%	16519	92.9%	



Статистик үзүүлэлтүүд

2021 онд аймгийн хэмжээнд 567 үр хөндөлт бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 157 тохиолдлоор буурч, 1000 амьд төрөлтөд 345,9 байна. Үр хөндөлтийн тоогоор улсад эхний байранд явж байна.

№	Байгууллага	Жирэмсний хяналтын хувь	Охидын жирэмслэлтийн хувь	Үр хөндөлтийн тоо
1	Баяндалай СЭМТ	90,3	0	12
2	Баян-Овоо СЭМТ	100	10	9
3	Булган СЭМТ	81	4,8	21
4	Гурвантэс СЭМТ	94,2	3,6	38
5	Мандал-Овоо СЭМТ	100	5,1	4
6	Манлай СЭМТ	91,3	17,4	12
7	Номгон СЭМТ	100	4,2	14
8	Ноён СДЭ	97	0	11
9	Сэврэй СЭМТ	97,4	2,6	5
10	Ханхонгор СЭМТ	91,7	4,2	15
11	Ханбогд СДЭ	94,3	5,2	28
12	Хүрмэн СЭМТ	88,9	0	7
13	Цогт-Овоо СЭМТ	82,8	10,3	12
14	Цогт-Цэций СДЭ	82,9	5,2	39
15	Өнө-Орших ӨЭМТөв	96,3	9,4	77
16	Энхийн хүслэн ӨЭМТөв	92	4	93
17	Шим билэг ӨЭМТөв	86,7	2,7	107
18	Бусад			63
	Аймгийн дундаж	90,6	4,9	567

Улсын дундаж: 168,1

Аймгийн дундаж: 104,5



Ололт амжилт

“Эх, хүүхдийн эрүүл мэнд” аймгийн хөтөлбөрийг 2017-2020 онд амжилттай хэрэгжүүлж, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтээ давуулан биелүүлсэн.

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2016 оны 10 сар			Хүрэх түвшин		Хүрсэн түвшин	Одоогийн түвшин	Өөрчлөлт
		Өмнөговь	Аймгуудын дундаж	Улсын дундаж	2018 он	2020 он	2020 оны ЭМ-ийн статистик	2021он	Өмнөх онтой харьцуулахад
1	Жирэмсний эрт хяналтын хувь	84.3	84.0	84.3	86.5	90	90,2	90,6	0,4%-р өссөн
2	Эхийн эндэгдлийн тоо	2	18	32	0	0	0	0	0
3	1 насны нялхсын эндэгдлийн хувь /1000 амьд төрөлтөд/	17.1	19.5	17.3	16.3	14.6	11,9	10,9	1-р буурсан
4	0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн хувь /1000 амьд төрөлтөнд/	29	24.5	21.3	24	20	14,2	12,2	2-р буурсан
5	Нярайн эндэгдлийн хувь /1000 амьд төрөлтөд ноогдох түвшин /	11.9		9.5	10.5	9.0	9,6	6,2	3,4-р буурсан
6	5 хүртэлх насны хүүхдийн осол гэмтлийн шалтгаант нас баралтын хувь	20			14	5	4	2	2 тохиолдлоор буурсан
7	19 ба түүнээс доош насны охидын жирэмслэлтийн хувь	8.6	5.3	5.1	6.7	5.3	3,1	4,9	1,8-р өссөн



Ололт амжилт

1. “Эх, хүүхэд, НҮЭМ” үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн эхний 5 аймгийн 1 болсон.
2. КОВИД-19 цар тахлыг амжилттай даван туулж байна. КОВИД-19 халдвартай жирэмсэн эмэгтэйчүүдийг БОЭТ-д тусгайлсан ор дэлгэж, мэргэжлийн эмч, мэргэжилтнүүд ажилласан. Мөн СДЭ, СЭМТ-д эмчилсэн. /эрсдэл багатайгаар даван туулсан/
3. ЖСАХ-ийг 5 төрлөөр нь АШЭМБ-уудад хэрэглэж хэвшсэн. 2-3 жилийн үе шаттай сургалтуудын үр дүнд бугалганы суулгацыг эх баригч нар тавих чадвартай болсон. /Онолын болон ажлын байрны сургалтуудаар Мэри стопс ОУБ, БОЭТ-ийн эмч нар сургагч багшаар хичээл заасан/



Анхаарах асуудал

!!! Амьгүй төрөлтийг бууруулах

!!! Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлээс сэргийлэх

!!! Охидын жирэмслэлт, үр хөндөлтийг бууруулах

!!! Хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийг бууруулах



- Эрүүл мэндийн боловсрол, зөв дадал хэвшлийг бий болгох
- НҮНЭ-ийн эрүүл мэндийг сайжруулах
- Жирэмсний хяналтыг чанаржуулах
- Байгууллага хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх

Цаашид:



Сэргийлж болох нярайн эндэгдэл, амьгүй төрөлтийг тэглэх дэлхий нийтийн хөтөлбөрт 2014-2035 онд 1000 нийт төрөлтөд ногдох амьгүй төрөлтийн түвшинг 2020 онд 14, аажмаар бууруулсаар 2035 онд 8 хүртэл бууруулах зорилт тавьсан.

✓ Монгол улсын эрүүл мэндийн салбарын баримталж буй бодлогын нэг хэсэг нь жирэмслэлт, төрөлтийг эх, хүүхдийн эрүүл мэндэд нийцсэн байдлаар төгсгөх, ураг эхийн хэвлийдээ эндэх тохиолдлыг бууруулах явдал юм.

✓ Улсын хэмжээнд амьгүй ураг төрүүлсэн тохиолдлын жирэмсний эрт үед хяналтад орсон хувь өндөр байдаг боловч ураг амьгүй болсон нь жирэмсний хяналт, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хангалтгүй байгааг харуулж байна.

✓ Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулахад, ялангуяа сэргийлэх боломжтой эндэгдэлд чухал нөлөө үзүүлдэг хүчин зүйл нь жирэмсний хяналтын чанарын асуудал юм.



Цаашид:

- ✓ Жирэмсний хяналтын эмч нарын мэдлэг, ур чадварыг сайжруулах сургалтыг тасралтгүй зохион байгуулах.
- ✓ Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед эхийн биеийн байдлыг зөв үнэлж, эмгэгийг эрт оношлон, эмчлэх
- ✓ Эхийн ноцтой хүндрэл, амьгүй төрөлт, нярайн эндэгдлийг бууруулахын тулд эхийн жирэмсэнтэй хавсарсан эмгэгийг эрт илрүүлж эмчлэх.
- ✓ Жирэмсний явцад эх, ургийн эмгэг байдлыг илрүүлж, гаж хөгжлийг оношилж, төрөлт удирдах тактикийг багаар хэлэлцэж, жирэмслэлтийг эрт үед нь шийдвэрлэх.
- ✓ Өндөр эрсдэлтэй жирэмсний нийгэм, биологи, амьдралын байдлын эрсдэлт хүчин зүйл болох 20-иос доош насны жирэмсэн, 30-аас дээш насны тулгар жирэмсэн, 35-аас дээш насны давтан төрөгчийг жирэмслэх үед нь онцгой хяналтад авч, төрөх үеийн тусламжийг чанартай үзүүлэх.
- ✓ Хувь хүн, гэр бүлийн гишүүдэд жирэмсний хяналтад орохын ач холбогдол, жирэмсэн үеийн аюултай шинж тэмдэг гэх мэт зайлшгүй мэдсэн байх суурь ойлголтыг зан төлвийн хэвшил болгох арга хэмжээг тасралтгүй авч хэрэгжүүлэх, эрүүл мэндийн тусламж хайх мэдлэгтэй болгох.
- ✓ Эхийн эндэгдлийн судалгаагаар эх жирэмсний хяналтад байсан, хяналтад эрт хамрагдсан боловч эндсэн тохиолдол гарсаар байгаа нь хяналтын чанар сул байгааг харуулж байна. Жирэмсний хяналтын чанарыг сайжруулахын тулд анхан шатны нэгжийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл мэдээллийг сайжруулах явдал юм. /Нэрийн хяналтыг нэвтрүүлэх/



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

АНХААРАЛ ТАВЬСАН ТАНД
БАЯРЛАЛАА